

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№23/581

ШУС, НУС

2022

**“ХУРААНГУЙ СЭТГҮҮЛ” БА “БЮЛЛЕТЕНЬ МОНТА” СОНИНЫ АНХНЫ
ДУГААРЫН НИЙТЛЭЛД ХИЙСЭН АЖИГЛАЛТ ШИНЖИЛГЭЭ**
(МОНЦАМЭ агентлагийн 100 жилийн ойд)

Т.Баасансүрэн*

*Монгол Улсын Соёлын Гавьяат Зүтгэлтэн, доктор (Ph.D), профессор

Түлхүүр үгс: МОНЦАМЭ, Хураангуй сэтгүүл, Бюллетень МОНТА, гадаад мэдээ, мэдээллийн тэнцвэр, мэдээллийн агентлаг.

МОНТА буюу МОНЦАМЭ агентлаг эдүгээгээс нэг зуун жилийн өмнө буюу 1921 онд үүсэн байгуулагджээ. Өнөөдөр түүхт 100 жилийн ой нь тохиож байна. Монголд үндэсний мэдээллийн агентлаг үүсэн байгуулагдсан нь Бүрэн эрхт Бүгд Найрамдах Монгол Ард Улсын түүхэнд тохиосон тэмдэглэлт том үйл явдал байлаа. Ялангуяа монголын хэвлэл мэдээллийн салбар дахь онцгой содон үзэгдэл байв. Үндэсний мэдээллийн агентлаг үүсэн байгуулагдсанаар монголын сэтгүүл зүй дэлхийн сэтгүүл зүйн хөгжлийн нийтлэг голдиролд нэгдэн нийлсэн байна.

Урьд нь Монголын сэтгүүл зүйг үндэслэгч, их соён гэгээрүүлэгч эрдэмтэн Жамсраны Цэвээний үүсгэж 1913 оны 3 дугаар сарын 6-нд анхных нь дугаар хэвлэгдсэн “Шинэ толь хэмээх бичиг” сонин 1914 он хүртэл 20 дугаар гаргаж, түүний үргэлжлэл болох “Нийслэл Хүрээний сонин бичиг” сонин 1915-1920 онд 104 дугаар гаргасан байдаг билээ. Энэ бол 1911 онд Монголд

мандсан үндэсний эрх чөлөөний хувьсгалын бодит үр дүн байсан ч 1919 онд нийслэл Хүрээг эзлэн авсан Хятадын эзлэн түрэмгийлэгчид Монголын автономитыг цэргийн хүчээр устгаж Монголын ард түмний эрх чөлөөний төлөөх тэмцэл, 1911 оны анхны үндэсний хувьсгалын үр дүнг нухчин дарах гэж оролдсон билээ. Гэвч монголын ард түмэн, түүний тэргүүний дэвшилт үзэлт хэсэг нөхөд нэгдэн нийлж улс төрийн намыг байгуулаад эрх чөлөө, тусгаар тогтнолынхоо төлөө ахин эрч хүчтэйгээр эрслэн босож Монголд 1921 оны ардын хувьсгалыг мандуулсан түүхтэй.

1921 оны ардын хувьсгалын бэлтгэлийг хангах үндсэн үүргийг “Монголын үнэн” сонин гүйцэтгэсэн бөгөөд 1920 онд хилийн чанад Эрхүү хотноо нууцаар 6 дугаарыг хэвлүүлэн гаргаж хилээр нууцаар нэвтрүүлэн оруулж түмэн олондоо түгээн ард түмнээ зэвсэгт тэмцэлд босож, Хятадын гамин цэрэг, хаант Оросын Барон Унгерний дээрэмчдийг эх нутгаасаа хөөн зайлуулахыг уриалан дуудсан байдаг билээ. “Монголын үнэн” сонины хилийн чанад дахь 6 дугаарыг шууд эрхлэн гаргагч нь 1921 оны ардын хувьсгалын дууч, Монголын утга зохиол, сэтгүүл зүйн шүүмж судлалыг

үндэслэгч Сономбалжирын Буяннэмэх байсан юм.

Монгол Улс цаашид оршин тогтнох уу, эс тогтнох уу, тусгаар тогтнолоо ахиад алдах уу, эсвэл байлдан ололтоо бататгах уу гэсэн хувь заяаны түүхэн эргэлт, торгон мөчийн ирмэг дээр Монголд үндэсний мэдээллийн агентлаг үүсэн байгуулагдсан бөгөөд хилийн чанадад илгээж дэлхий дахинаа зарлан мэдээлж сонсгосон анхны мэдээ нь “Монголчуудын бослого” нэртэй товч мэдээ байлаа. Уг мэдээнд “Чита. 1921 оны гуравдугаар сарын 23 /Дальта/. Троицкосавск /Дээд Шивээ Т.Б./-аас авсан мэдээнээс үзвэл, Унгерн, Комаровский нарын удирдсан хэрмэл дээрэмчин бүлэг цагаантан хийгээд санаа сэтгэлээр бүрэн дампууран унасан хятадын цэргийн эрхтний аллага таллагад нэрвэгдсэн монголчууд тэмцэн босож Маймаа /Хиагт Т.Б./ суурин болон түүний ойролцоох газруудыг байлдан эзлээд Монголын ардын Засгийн Газрыг зарлан тунхаглав.

Дэлхийн империалистуудын түрэмгий ашиг сонирхлыг илэрхийлсэн оросын цагаантны балмад бодлогын эсрэг Монголын засгийн газар шийдвэртэй тэмцэж, тусгаар тогтнолоо хамгаалан нутаг дэвсгэртээ аж төрж байгаа энгийн номхон орос, хятад, монгол иргэдийн энх амгалан байдлыг аль болохоор хамгаалах зорилт тавьж байна.

Маймаад /Хиагт Т.Б./ гарсан улаан монголчуудын бослого нь Монголын хүн амын бүх давхаргыг хамарч ойролцоох хошуудад амжилттай дэлгэрч байна гэж хилийн районоос мэдээллээ /Роста/ (Правда, 2021) гэжээ.

Энэ бол МОНТА буюу МОНЦАМЭ агентлагийн анхны мэдээ. Их жанжин Дамдины Сүхбаатарын даалгавраар

Монгол Ардын Хувьсгалт Армийн Улс төрийн газрын даргын зөвлөх-сургагч, МОНТА-гийн эрхлэгч Оросын иргэн А.Г.Демко дээрх мэдээг бичиж илгээсэн байна. Тэр тухайгаа зөвлөх-сургагч А.Г.Демко “...1921 оны 3 дугаар сарын 17-ны шөнөөс 18-ны өдөр Д.Сүхбаатарын удирдлага дор явсан журамт цэргийн отрядын нэгэнд би оролцож явлаа. 1921 оны гуравдугаар сарын 18-ны өглөө эрт Монголын Хиагт-Маймаа хотноо үүрлэсэн хятадын цэргийн анги руу довтлон орж, нөхөр Сүхбаатарын удирдсан Монгол цэргүүд хятадын цэргийг монголын энэхүү хотоос хөөн зайлуулсан юм. 1921 оны гуравдугаар сарын 18-ны энэ гайхамшигт өдөр МАН-ын Төв Хороо, Монголын ардын хувьсгалт түр засгийн газар нутгийн тэр хэсгийг өөрийн мэдэлд чөлөөлөн авсны дараа би Монголын цахилгаан мэдээний газрын эрхлэгчийн хувьд Москва руу РОСТА-гийн нэр дээр монголын газар нутаг дээр Ардын хувьсгалт түр засгийн газар тогтоосон тухай мэдээг явуулсан юм. Энэхүү цахилгаан мэдээг МОНТА-гаас иш татаж “Правда” сонинд тэр даруй нийтэлсэн байж билээ” (Миний нэр, миний гэр МОНЦАМЭ, 2001) гэж дурсан бичсэн байна.

Ингэж МОНТА буюу МОНЦАМЭ 1921 оны ардын хувьсгалын шуурган тэмцлийн халуун гал дундаас Хиагт-Маймаа буюу эдүгээгийн Алтанбулаг хотноо анх төрж мэндэлсэн түүхтэй аж. Энэ нь хувьсгалын үйл хэрэг, шинэ Монгол Улсын цаашдын ажил үйлсэд үндэсний мэдээллийн агентлаг зайлшгүй хэрэгцээ шаардлагатай байсныг хөдөлшгүйгээр нотлон харуулсан чухал баримт юм.

Монгол Ардын Намын Төв Хорооны 1921 оны тавдугаар сарын 19-ний өдөр хуралдсан хурлын тогтоолын хоёрдугаар зүйлд, “МОНТА” хэмээх нэр

бүхий цахилгаан мэдээг сурвалжлан хурааж нэвтрүүлэх газрыг зохион байгуулах тухай хэлэлцээд “МОНТА” хэмээх нэр бүхий бөгөөд монголын цахилгаан мэдээг сурвалжлан хурааж нэвтрүүлэх газар байгуулахаар төлөвлөн ирүүлснийг зүйтэй хэмээн үзэж засгийн газар батлуулахаар шилжүүлэв” (Намын анхдугаар их хурлын материал, гар бичмэл эх) гэжээ.

МАН-ын Төв Хорооны энэ тогтоолын заалт ёсоор 1921 оны долдугаар сарын 19-нд хуралдсан Монголын Засгийн газрын гишүүдийн зургаадугаар хурлаар хэлэлцсэн есөн асуудлын хоёрдугаар зүйлд “Шуудан бичиг, цахилгаан мэдээний ерөнхий хороо”-г байгуулах тухай хэлэлцээд /Уг хороог/ байгуулахаар тогтсон тул гүн Цэдэвсүрэнг ерөнхийлөн захирах түшмэдэд, И.С.Маслаковыг туслах түшмэдээр тус тус тохоон томилжээ. Ерөнхий хороог Дотоод Яамнаа захирах ба албан хаагчдыг ерөнхий сайд өөрөө зохисыг үзэж хянан тогтоож батлан суулгаваас зохино хэмээхээс гадна албан хаагчдыг чадвал монгол хүнээр хаалгаваас зохино гэжээ. Монголын цахилгаан мэдээ, шуудан бичгийн ерөнхий хороог байгуулахаар шийдвэрлэсэн болоод байгуулсан тухай МАН-ын Төв Хороо, Засгийн газрын хуралд монголын хувьсгалын их удирдагч Д.Сүхбаатар биеэр оролцсон байна. Ингэж Монголын цахилгаан мэдээний анхны агентлаг ардын хувьсгал ялсны дараа 1921 оны долдугаар сарын 19-нд албан ёсоор байгуулагджээ. Монголын цахилгаан мэдээний анхны агентлаг – “МОНТА” нь нөхөр Д.Сүхбаатарын санаачилга, шууд оролцоотой байгуулагдсаныг энэхүү түүхэн баримт нотолж байна. Агентлагийн албан хаагчдыг Ерөнхий сайд өөрөө шууд мэдэж томилж байх нь

зүйтэй. Аль болохоор монгол хүнээр алба хаалгавал зохилтой гэсэн байна. Тухайн цаг үеийн зайлшгүй нөхцөл байдлаас үүдэж эхэн үед Оросын мэргэжилтний зөвлөмж дэмжлэг хэрэгтэй байсан аж.

1921 оны 11 дүгээр сарын 1-нд хуралдсан Засгийн газрын 21 дүгээр хурлаар МОНТА хэмээх Монголын цахилгаан мэдээний агентлагийн ажиллах дүрмийг баталжээ. Шуудан бичиг, цахилгаан мэдээний ерөнхий хороо, МОНТА нь эхлээд Дотоод Яаманд харьяалагдаж байснаа 1921 оны 11 дүгээр сард Гадаад явдлын Яаманд харьяалагдах болжээ. МОНТА гэж нэршсэн Монголын цахилгаан мэдээний агентлаг хувьсгалын ялалтыг бататгахад туслах зорилгоор ажлаа явуулж тэр үеийн сонин хэвлэлд гадаадын мэдээ нийлүүлж, өөрийн улс орны байдлын тухай мэдээг гадагш нэвтрүүлдэг байлаа. Тэр ч байтугай анх байгуулагдсанаасаа хойш арван сарын дараа өөртөө “Бюллетень Монгольского Телеграфного Агентства”-/сонсгол мэдээ/, “Хураангуй сэтгүүл” гэдэг биеэ даасан хоёр сониныг орос, монгол хэлээр гаргаж эхэлсэн байна.

“Бюллетень Монгольского Телеграфного Агентства” гэдэг нэртэй сонинг 1922 оны тавдугаар сарын 25-наас эхлэн Монголын цахилгаан мэдээний агентлаг /МОНТА/ гаргажээ. Энэ сонин 7 хоногт хоёр удаа орос, монгол хэлээр гардаг байсан бөгөөд орос-монгол хэвлэлийн хороонд хэвлэдэг байсан гэнэ.

“Бюллетень МОНТА” сонины монгол орчуулга нь “Хураангуй сэтгүүл” нэртэйгээр 1922 оны 6 дугаар сарын 22-ноос эхлэн гарчээ. Намын Төв Хорооны 1922 оны тавдугаар сарын өргөтгөсөн хурлаар “Уриа” хэмээх сэтгүүлийг хуучин хэвээр явуулахаас гадна МОНТА

хэмээх цахилгаан мэдээний хороог мөнхүү сэтгүүлийн хорооноо хавсарган нийлүүлнэ” (МАХН-ын Төв архивын 1 фондын 24 дүгээр товъёгийн 46 дугаар нэгжийн 34 дүгээр тал) гэснээс үзэхэд МОНТА-гийн гаргах “Хураангуй сэтгүүлийг” нам, засгийн төв хэвлэл “Уриа” сонинтой хавсран гаргаж байхаар заасныг өгүүлжээ.

Тэгэхдээ “Бюллетень МОНТА” сониныг Монголд оршин сууж байгаа орос иргэд болон улмаар Зөвлөлт Орос, Алс Дорнодын уншигчдад Монгол Улс, монголчуудын аж амьдралыг танилцуулах зорилгоор гаргаж байсан байна. Тиймээс уг сонинд монгол орны тэр үеийн байдлаас товч тодорхойгоор бичдэг байсан байна.

“Хураангуй сэтгүүл” нь шинэ тулгар байгуулагдсан нам, засгийн бодлого шийдвэрийг олон түмэнд сурталчилдаг байв. Энэ хоёр сонинд тэр үеийн олон улсын хоорондын байдлын тухай, ялангуяа Зөвлөлт Орос улс, Хятад, Япон, Америк, Англи, Франц, Герман зэрэг улс орны тухай ихэвчлэн мэдээлж байжээ.

МОНТА-гийн “Бюллетень Монгольского Телеграфного Агентства” сонины эрхлэгчээр Оросын хувьсгалч В.Г.Диадани гэдэг гүрж хүн ажиллаж байсан аж.

“Бюллетень МОНТА”, “Хураангуй сэтгүүл” гэдэг энэ хоёр сонин 1923 оны зургадугаар сарын 28 хүртэл үргэлжлэн гарсан байна.

“Бюллетень МОНТА” 150-250 хувиар, “Хураангуй сэтгүүл” 500-1000 хувиар хэвлэгдэж байсан бөгөөд нэг жил илүү хугацааны дотор “Бюллетень МОНТА” 100 гаруй дугаар, “Хураангуй сэтгүүл” 96 дугаар хэвлэгдэн гарчээ. Монгол Улсын түүхийн төв архивын ашиглалтын фондод “Бюллетень Монгольского Телеграфного Агентства” сонин /эх, дунд, сүүлчээс олон дугаар дутуу/, “Хураангуй сэтгүүлийн” бараг бүх дугаар хадгалагдаж байна.

МОНТА-гийн энэхүү хоёр сонинд ардын засгийн анхны жилүүдэд нам, засгаас авч хэрэгжүүлсэн гол гол арга хэмжээг мэдээлэн сурталчилж, тус улсын дотоод, гадаадын байдлаас өөрийн хуудсандаа өргөн тусгаж байжээ.

“Монгол, Орос хэлээр гарч байсан /тэдгээр/ бяцхан сонин тэр үеийн монголын нийгэм, улс төрийн байдлыг уншигчдад зөв мэдээлснээр барахгүй гадаад, дотоодын мэдээг өөрийн уншигчдад сонордуулж бас Монгол улсыг гадаадын уншигчдад сурталчилж байв” (Дэлэг.Г, 1965) гэж доктор Г.Дэлэг тэмдэглэн бичиж үлдээсэн байна.

«

**“Бюллетень МОНТА”
сониныг Монголд оршин сууж
байгаа орос иргэд болон улмаар
Зөвлөлт Орос, Алс Дорнодын
уншигчдад Монгол Улс,
монголчуудын аж амьдралыг
танилцуулах зорилгоор гаргаж
байсан байна. Тиймээс уг
сонинд монгол орны тэр үеийн
байдлаас товч тодорхойгоор
бичдэг байсан байна.**

**“Хураангуй сэтгүүл” нь шинэ
тулгар байгуулагдсан нам,
засгийн бодлого шийдвэрийг
олон түмэнд сурталчилдаг
байв. Энэ хоёр сонинд тэр
үеийн олон улсын хоорондын
байдлын тухай, ялангуяа
Зөвлөлт Орос улс, Хятад, Япон,
Америк, Англи, Франц, Герман
зэрэг улс орны тухай ихэвчлэн
мэдээлж байжээ**

»

МОНТА нь тус орны нийгэм, улс төр, эдийн засаг, соёл, гэгээрэл, эрүүл мэндийн салбарт олж бий хувьсгалт шинэ өөрчлөлт, амжилтыг тусгасан мэдээ, материалыг гадаадад мэдээлэх, гадаадаас шуурхай мэдээ хүлээн авч тэр үеийн “Өргөө” /одоогийн Улаанбаатар/ хотод гарч байсан сонин хэвлэлд нийлүүлж байжээ. 1920-1921 онд Монголын харилцаа холбооны хэрэгсэл Хятадын гамин цэрэг, цагааны оргодол барон Унгерний дээрмийн дайн самуунд эвдрэн сүйдсэн учир 1922 оноос цахилгаан утасны шугамуудыг сэргээн засварлаж эхэлжээ. Тиймээс 1922 оны VI сараас МОНТА-гийн мэдээлэх үйл ажиллагаа үлэмжхэн идэвхэжсэн байдаг юм.

“Бюллетень МОНТА”-гийн 1923 оны нэгдүгээр сарын нэгний 50-51 /хоёр дугаарыг хавсарган гаргасан аж/ дүгээрт МОНТА ажиллаж эхэлснээс хойших хагас жилийн тайланг бичсэн нь: “МОНТА” нь Өргөө хотод болж байгаа Монголын улс төр, нийгэм, эдийн засаг аж ахуйн амьдралын тухай сонирхолтой мэдээнүүдийг цахилгаанаар илгээн мэдээллээ. VI сараас XII сард 3206 үгтэй 22 мэдээг Москва, Чита, Эрхүү, Новониколаев хотод илгээсэн байна” гэжээ.

МОНТА нь цөөхөн орон тоотой үндэсний цомхон агентлаг байж. Гаднаас ирсэн мэдээг сонинд өгөх, дотооддоо боловсруулсан мэдээг гадагш дамжуулах үндсэн үүрэг гүйцэтгэж байв.

“Бюллетень МОНТА” ба “Хураангуй сэтгүүл”-ийн бүх дугаарт /Монголд байгаа/ миний бие урьд нь ажиглалт шинжилгээ хийж үзсэн бөгөөд үр дүнг өөрийн биечлэн бичиж боловсруулж гардаж хэвлүүлсэн “Миний нэр, миний гэр-МОНЦАМЭ” /УБ, 2001/, “МОНТА буюу МОНЦАМЭ: түүний өчигдөр ба

өнөөдөр, маргааш” /УБ, 2002/, “Мэдээ мэдээлэл, хууль эрх, ёс зүй: анхаарал татсан зарим асуудал” /УБ, 2002/, “ХХ зууны эхэн үеийн Монголын чөлөөт хэвлэл” /Тэргүүн дэвтэр, I ба II хэсэгтэй/ /УБ.2009/, мөн “Мэдээллийн агентлагийн нийгэмд гүйцэтгэх үүрэг, хөгжлийн чиг хандлага” /2016/ зэрэг ном зохиолд толилуулж өргөн олон уншигч, сэтгүүл зүйн судлаачдын сонорт хүргэж байсан билээ.

Иймд энэ удаад олон юм нуршихгүй, зөвхөн ганцхан зүйлд, тодотговол МОНТА буюу МОНЦАМЭ агентлагаас 1922 оны 5 дугаар сарын 25-ны өдөр гаргасан “Бюллетень Монгольского Телеграфного Агентства” /“МОНТА”/ сонины орос хэл дээрх дугаар нэг, мөн олноо өргөгдсөний 12-р оны 4 сарын 27 буюу Аргын улирлын 6-р сарын 22-нд хэвлүүлсэн “Хураангуй сэтгүүл”-ийн дугаар нэгийн талаар та бүхэнтэй өөрийн санал бодлыг хуваалцвал илүү сонин болов уу гэж бодлоо. “Бюллетень МОНТА” ба “Хураангуй сэтгүүл” анхны дугаар адилхан орос монгол хэл дээр хэвлэгдсэн боловч адил ба зөрүүтэй зүйлс бас бий. Нөгөөтээгүүр 2000 оны эхээр Улсын нийтийн төв номын сан болоод Улсын архивын газраас надад дээрх хоёр сонины орос хэл дээрх анхны дугаар олдоогүй юм, монгол хэл дээрх нь бол байсан. Аз болоход бүр сүүлд буюу хэдэн жилийн дараа Монгол Улсын хөдөлмөрийн баатар, Ардын уран зохиолч Лодонгийн Түдэв ахайтан “Бюллетень МОНТА” сонины №1-ийг надад дурсгал болгож өгсөн билээ. Ингээд анхны хоёр дугаарыг харьцуулан үзэж зэрэгцүүлэн шинжих сайхан бололцоо бүрдсэнээ та нартайгаа өнөөдөр зориуд хуваалцаж байна. Тэмдэглэн хэлэх хэд хэдэн зүйл байна. Үүнд:

Нэгд, Юун түрүүнд сонирхуулах зүйл бол орос хэл дээрх “Бюллетень МОНТА” сонины анхны дугаар нь 1922 оны 5 дугаар сарын 25-нд, харин монгол хэл дээрх “Хураангуй сэтгүүл”-ийн эхний дээж дугаар 1922 оны 6 дугаар сарын 22-нд тус тус гарчээ. Бараг нэг сарын зайтайгаар уншигчдад хүрсэн аж. Энэ нь тухайн цаг үед Монгол Улсыг гадаад ертөнцөд сурталчлах хэрэгцээ шаардлага ус, агаар мэт хэрэгтэй байсантай холбоотой байх өндөр магадлалтай. Тэр нь орос хэл, түүгээр дамжиж ОХУ-ын иргэд, гадаад ертөнцөд хүрэхээс өөр гарц байсангүй.

МОНТА буюу МОНЦАМЭ агентлагт Орос зөвлөлтийн мэргэжилтэн ажиллаж байсан, анхны сонин сэтгүүлийг орос, монголын хэвлэлийн хороонд хэвлэдэг байсан зэрэг хүчин зүйлтэй мөн холбоотой юм. “Бюллетень МОНТА”-г эрхлэн гаргагч нь гүрж гаралтай Оросын иргэн В.Г.Дадиани гэгч байжээ. Мөн монголчуудад дэлхий дахинд болж байгаа үйл явдал, ялангуяа хөрш зэргэлдээх гүрнүүд, тэндхийн ард түмнүүдийн аж амьдрал, хөгжил дэвшил, хувьсгалт үйл явц туйлын сонирхолтой байв. Ийм хэрэгцээ шаардлага байсан ч түүнийг хангах сонин хэвлэл урьд нь Монголд байсангүй.

Хоёрт, орос хэл дээрх “Бюллетень МОНТА”, монгол хэл дээрх “Хураангуй сэтгүүл” аль алийг 7 хоногт тус бүр хоёр удаа хэвлүүлэн гаргаж олон нийтэд тараадаг байжээ. “Бюллетень МОНТА”-г ойролцоогоор 150-250 хувиар хэвлэж нийслэл Хүрээн дэх орос иргэд, оросын худалдаачдад, харин “Хураангуй сэтгүүл”-ийг 500-1000 хувиар хэвлээд монголчуудад түгээдэг байсан аж. Эхлээд 10, 20 ба 25 копейкоор, сүүлдээ 15 центээр борлуулж байсан байна. 1921 онд 7 хоногт

хоёр гардаг сониныг өнөөдрийн өдөр тутмын хэвлэлтэй зүйрлэж бараг болно. Учир нь тухайн цаг үеийн хэвлэх үйлдвэрийн хүчин чадал мэргэжлийн боловсон хүчин, тэрчлэн цаас будгийн хангамж нийлүүлэлт, тугалга хайлуулах, үсэг өрж бэлтгэх гар ажиллагааны бүх зүйл харьцангуй доогуур түвшинд хязгаарлагдмал байсныг бас бодолцох ёстой.

Гуравт, 1922-1923 оны хооронд “Бюллетень МОНТА”-гийн 100 гаруй дугаар, “Хураангуй сэтгүүл”-ийн 96 дугаар хэвлэгдэн гарч уншигчдын гарт хүрчээ гэсэн мэдээлэл бий.

Миний бие өөрийн бичсэн “ХХ зууны эхэн үеийн Монголын чөлөөт хэвлэл” /Тэргүүн дэвтэр, II хэсэг/ номонд “Хураангуй сэтгүүл”-ийн 20 дугаарын нийтлэлийг орчин цагийн кирилл руу буулгаж, “Бюллетень МОНТА” сонины 41 дугаарыг орос хэлнээс монгол руу хөрвүүлснийг багцлан оруулсан болно. Улсын төв номын сангаас надад олдсон дугаарууд нь энэ юм. Хэдэн жилийн дараа хэрэгцээ шаардлага гарч, тэдгээр дугаарын гэрэл зургуудыг авхуулахаар хүн илгээж шүүрдэж үзүүлэхэд бараг ихэнх нь олдохоо больсон байна гэсэн мэдээлэл хүлээж авсан билээ.

2002 онд Улсын төв номын санд хуучин монгол бичгээр 1922-1923 онд хэвлэж гаргасан “Хураангуй сэтгүүл”-ийн хорин дугаар, харин “Бюллетень МОНТА” сонины 1922 оны 27 дугаар, 1923 оны 35 дугаар буюу нийт 63 дугаар хадгалагдаж байсан. Тэгэхэд “Бюллетень МОНТА” сонины орос хэл дээрх 1922 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн № 1 дугаар номын санд байгаагүй юм.

Дөрөвт, “Бюллетень МОНТА” сонины анхны дугаар хоёр нүүрээр хэвлэгдэн гарсан байх бөгөөд нэг ба

хоёр дахь нүүр тус бүр есөн мэдээ буюу нийт 18 мэдээлэл нийтэлжээ.

Харин “Хураангуй сэтгүүл”-ийн анхны дугаарт 14 мэдээллийг багтаасан байна. Эдгээр нь гол төлөв “Бюллетень МОНТА”-д нийтлэгдсэн мэдээ мэдээллийг монгол хэл рүү шууд хөрвүүлэн буулгасан байх бөгөөд тэгэхдээ “Движение товаров”, “Вечер национальностей”, “Юм юмнаас” хөмсгийн дор гарсан “Сколько населения в Монголии”, “К исследованию Монголии”, “Зарлал” гэсэн гарчигтай таван мэдээллийг орчуулалгүй орхиод, оронд нь “Бага Сүй Шү Жан алагдсан учир”, “Эзний зааврыг дагасан” гэсэн 2 шинэ мэдээг оруулсан байна.

Энэ нь орос ба монгол хэл дээр хэвлэгдсэн анхны хоёр дугаар хоорондын зай бараг нэг сар орчим байгаа, тэр хооронд нийтэлбэл зохилтой шинэ чухал үйл явдал энд тэнд болсонтой холбоотой хэмээн таамаглаж байна.

Тавд, зөрүүтэй байгаа мэдээллүүдийг сонирхож үзвэл орос хэл дээрх “Бюллетень МОНТА”-гийн “Движение товаров” /“Бараа товарын тээвэрлэлт”/ нэртэй товч мэдээнд Өргөөд орж ирж буй тэмээн жингийн цуваа жигд бус харилцан адилгүй, зарим өдөр 50 тэмээ ачаа орж ирж байхад заримдаа 300-д хүрч байна. Энэ нь орон нутагт барааны худалдаа борлуулалт жигдэрч чадаагүйтэй холбоотой юм. Энэ нь Өргөө хотноо барааны үнэ ханш унах, өсөхөд шууд нөлөөлж үнэ өртгийг хэлбэлзүүлж байна. Сүүлийн үед үнэ нэмэгдэх хандлагатай боллоо.

Тарваганы арьс сонирхсон гадаадын фирмүүдийн эрэлт хэрэгцээ маш өндөр байна. Тарваганы сайн чанарын нэг ширхэг арьс 60 копейк хүрч байгаа ч худалдаалагчдын идэвх чармайлт сул байна. Гол учир шалтгаан нь малчдад

дарь сум олдохгүй, Хятадаас тэдгээрийг оруулж ирэхийг хориглосонтой холбоотой аж гэжээ.

“Үндэстэн ястнуудын үдэшлэг” /Вечер национальностей/ хэмээх мэдээлэлд 5 дугаар сарын 20-21-нд Ардын ордонд өвөрмөц тоглолт боллоо. Алс дорнодын ястан үндэстэн-халх, цахар, ордос, барга, Байгалийн цаадах ба Эрхүүгийн буриадууд, Астраханы болоод Донын Халимагууд, төвд, татаар, солонгос, хятад иргэд оролцож үндэснийхээ дуу, хөгжим, бүжгийн үзүүлбэр үзүүлэв.

Заал үзэгчдээр пиг дүүрч, оролцогч эрэгтэй ба эмэгтэй жүжигчдийн тоглолт үнэхээрийн амжилттай болж өнгөрөв.

Энэхүү урлагийн тоглолтыг Өргөө хот дахь Цагаачдын нийгэмлэгийн Холбооны хороо, нөхөр Дашеев, Баторнум, Буян-Эмэх /Сономбалжирын Буян-нэмэх байж таарна. Тэр тухайн цаг үед Хүрээн дэх бүх дуу, хөгжмийн тоглолтыг зохион байгуулахад манлайлан оролцож байсан бөгөөд МХЗЭ-ийн Төв Хорооны даргаар ажиллаж байсан. Т.Б./, Турханаев зэрэг хүмүүс Ардын Ордны эрхлэгч нөхөр Боковын идэвхтэй дэмжлэгээр Халимаг улсын өлсгөлөнд нэрвэгдэгсдэд зориулж уг тоглолтыг зохион байгуулав.

Хоёр өдрийн тоглолтоос наймаас есөн зуун долларын орлого цуглуулсан байна гэжээ.

“Юм юмнаас” хөмсгийн дор “Монголын хүн ам хэд вэ?” /Сколько населения в Монголии/, “Монгол судлал” /К исследованию Монголии/ хэмээх онц сонирхолтой хоёр мэдээлэл оруулжээ.

Эхнийхэд нь зохиолч И.Майскийн тооцооллоор нийт монголчуудын тоо өвөрмонголчууд, Алтайн хязгаарын монголчууд, тэрчлэн Хятадын хэд хэдэн

эзэмшил нутаг дахь монголчуудыг оруулаад хоёр сая орчим байна.

Манай тусгаар тогтносон Монголд 1918 оны байдлаар хүн амын нийт тоо 647 мянга, үүнээс 542 мянган монголчууд, 100 мянган хятад, 5 мянган орос байв гэсэн бол хоёр дахь мэдээнд саяхан Монголын нутгийн гүнд Америкийн газар зүй болон геологи хайгуулын хэсэг судлаачид ирж ажиллав.

Яг ийм шинжилгээ судалгааны ажлыг Оросын эрдэмтэн агрономич В.Писарев бас хийж байгаа, тэр нь Сибирийн газар тариаланд ихээхэн практик ач холбогдолтой зарим ургамал, үр тарианы үрийг эрж хайж байгаа юм.

Ингэхийн тулд Г.Писарев тус улсын газар нутгийг морь унаж бүтэн тойрох шаардлагатай болж байгаа бөгөөд намар гэхэд Монголын хойт хилээр Сибирь рүү нэвтрэн орохоор төлөвлөж байгаа болно гэсэн байна.

Залгуулаад “Зарлал” буланд хоёр товч мэдээ нийтэлжээ. Эхнийхэд нь Л.Андреевын “Анфиса” жүжгийг В.Г.Титовын удирдлага дор найруулан тавихаар бэлтгэж байна гэсэн бол дараагийн зарлалд “МОНТА”-гийн /Монгол Цахилгаан Мэдээллийн Агентлаг/ Тамгын газар Монголын армийн улстөрийн газрын байранд байрлаж байна гэжээ. Дор нь эрхлэн гаргагч нь Улстөрийн газар. Редактор В.Г.Дадиани. 150 ширхэгээр хэвлэв (Бюллетень Монгольского Телеграфного Агентства, 1922) гэжээ.

Үүн дээр орос эх дээрх буюу “Бюллетень МОНТА” сонинд хэвлэгдээгүй, харин монгол хэл дээрх “Хураангуй сэтгүүл”-д гарсан 2 мэдээний агуулгыг нэмж хэлэх учиртай.

“Бага Сүй Шү Жан алагдсан учир” хэмээх эхний мэдээнд “Бага Сүй Шү Жанийн алагдсан нэгэн хэргийг хэдий-

нээс нуусан нь сая илэрч Сүй Шү Жан болбоос Ан Во хүрээлэнгийн хэмээгч Жан Золины адил Японы бодлогыг баримталсан хүн ажгуу. Жан Золин Ан Во хүрээлэнгийн тэргүүлэгчдийг өөрийн зорилтод хэрэглээд дараа түүний гэрчээс салахыг санаж бага Сүйг хорложээ” гэсэн байна.

“Эзний зааврыг дагасан” гэх гарчигтай дараагийн мэдээнд “Харбин хотын хятад эрх баригчид тус хотын сонин зохиогч нарыг зарлан ирүүлж сонин бичгийн хороодыг хаана хэмээн занажээ. Владивосток хотын Меркуловын засгийг шүүмжлэхийг хоригложээ. Үүнийг үзвээс Меркуловыг хамаарч бүхий Японы хүчилснээс ийм хэрэг гарсан буй заа” (Хураангуй сэтгүүл., Олноо өргөгдсөний 12-р он) хэмээжээ.

Эдгээр нэр дурдсан 7 ширхэг мэдээнээс бусад нь монгол ба орос хэл дээрх “Хураангуй сэтгүүл” ба “Бюллетень Монгольского Телеграфного Агентства” /”МОНТА”/ сонинд аль алинд нь бүрэн эхээрээ хэвлэгдсэн байна. Харин монгол орчуулгад зарим үг, өгүүлбэрийг орхигдуулсан, хөрвүүлэхдээ утга агуулгыг бүдгэрүүлсэн зэрэг гэм согог буй нь тухайн цаг үед орос хэлийг төгс төгөлдөр мэддэг мэргэжилтэн цөөн байсантай холбоотой буй заа.

“Хураангуй сэтгүүл”-ийн эхэнд “Энэхүү хураангуй сэтгүүлийг Уриа сэтгүүл МОНТА хэмээх Цахилгаан мэдээний хорооноос 7 хоног тутам 2 удаа монгол үсгээр гаргана” гэж бичсэн бол ““Бюллетень Монгольского Телеграфного Агентства” /”МОНТА”/ хэмээх орос хэл дээрх сонин өөрийн нэрийнхээ дор “Выходит не реже двух раз в неделю на монгольском и русском языке” буюу 7 хоногт монгол, орос хэл дээр хоёроос доошгүй удаа гаргана.

№1, 1922 оны 5 дугаар сарын 25. Үнэ 10 коп гэж бичжээ.

Тодотгон тайлбарлахад тухайн цаг үед гарч байсан “Уриа” сонин бол 1920 оны “Монголын үнэн” сонины үргэлжлэл, өөрөөр хэлбэл эрх баригч МАН ба төр засгийн төв хэвлэл юм. Энэхүү сонины газар болоод Монголын цахилгаан мэдээний хорооноос “Хураангуй сэтгүүл”-ийг 7 хоног тутам 2 удаа гаргана гэжээ. Үүнийг МОНТА буюу МОНЦАМЭ агентлаг үүсэн байгуулагдахаасаа эхлээд “Үнэн” сонины газартай нягт холбоотой, хамтран ажиллаж байсан гэсэн дүгнэлтийг хийх боломжийг бидэнд олгож байгаа болно. Тэгэхдээ нийтлэлийн бодлогоороо “Уриа” сониныг аялдан дагалдаж байсангүй.

Орос хэл дээрх тодотгол алга байгаагаас үүнийг харж болно. 7 хоногт 2-оос доошгүй удаа хэвлэнэ л гэсэн байна. Орос хэл дээрх эхийг эрхлэн гаргагч нь Оросын иргэн В.Г.Диадани. Анхны дугаарыг нь ажилхад цаг хугацааны хувьд орос хэл дээрх эх түрүүлж, “Хураангуй сэтгүүл” сүүлдэж гарчээ. Мөн бидэнд байгаа дээрх 2 сонины № 26-г зэрэгцүүлж үзэхэд орос хэл дээрх эх нь 1922 оны 9 дүгээр сарын 30-нд, харин монгол хэл дээрх нь болохоор аргын улирлын арван сарын нэгэнд хэвлэгдсэн байх аж. “Бюллетень Монгольского Телеграфного Агентства” /“МОНТА”/ сонин № 26 гэж тэмдэглэсэн байхад “Хураангуй сэтгүүл” болохоор № 26, 27 гэжээ.

“Бюллетень МОНТА”-гийн № 30 нь 1922 оны 10 дугаар сарын 20-нд гарсан байхад “Хураангуй сэтгүүл”-ийн № 30, 31 дэх хавсарсан дугаар аргын улирлын арван сарын 23-нд хэвлэгдсэн байх жишээтэй /тэгэхдээ хоёр дугаарыг нэгтгэж хамтатган гаргасан/ байна. Үүнээс орос эх нь түрүүлж гардаг,

түүнийг нь “Хураангуй сэтгүүл” монгол руу хөрвүүлж буулгадаг зэргээс улбаалж бага зэрэг хожимдосхийж хэвлэгддэг байжээ гэж хэлж болохоор байна. Мэдээ мэдээллийн цаг хугацааг алдахгүйн үүднээс “Хураангуй сэтгүүл” хэмээх монгол сонинд зарим шинэ мэдээг нэмж хэвлэдэг, эсвэл хоёр дугаарыг нэгтгэж гаргадаг байсан байна.

Эдгээрийг багцалж үзэхэд “Бюллетень МОНТА” ба “Хураангуй сэтгүүл”-ийн нийтлэлийн бодлого нам, төрийн төв хэвлэл – “Уриа” сониноос хараат бус байсныг илтгэн харуулна. Өөрөөр хэлбэл өөрийн гэсэн нийтлэлийн өвөрмөц содон бодлоготой, Монголын Цахилгаан Мэдээний Агентлагийн бие даасан хэвлэл байсан байна. Хэзээ, хаана, юу болов гэдэгт л хариулт өгөхийг чухалчилдаг сонинууд байжээ. Илэрхий ангич, намч зарчим баримталж байсангүй гэж хэлэх гээд байна.

Зургаадугаарт, Дээр ярьж хэлсэн бүгдийгээ баримтжуулж нотлохын тулд “Хураангуй сэтгүүл” болоод “Бюллетень МОНТА” сонины аль алинд нь байгаа мэдээ мэдээллүүдийг одоо та бүхэнд бүрэн эхээр нь толилуулан сонирхуулъя. “Хураангуй сэтгүүл”-д хөрвүүлэгдсэн эх хэллэг, хөрвүүлгээр нь үзүүлж байгаа болно. Үүнд:

ХУРААНГУЙ СЭТГҮҮЛ. Дугаар 1. Олноо өргөгдсөний 12-р он. 4 сарын 27. Аргын улирлын 6-р сарын 22. Энэхүү хураангуй сэтгүүлийг Уриа сэтгүүл МОНТА хэмээх цахилгаан мэдээний хорооноос 7 хоног тутам 2 удаа монгол үсгээр гаргана.

Түрэмгий өшөөтний зохиосон худал үг нь: Чөлөөт эрхтэй Монгол Улсын олон дайсан эгнэгт амар суухгүй бөгөөд тэд нар өөрсдийн чухал бодлогыг нуухыг эрхэлж зүйд үл нийлэлцэх худал үг зохиомуй. Үлгэрлэ-

вэл Харбин хотын оросын сонин бичигт хятадын эрх баригчдын үгийг баримталж өгүүлэх нь

Монгол Засгийн газраас Хөлөнбуйрыг эзэрхэн авах бодлого буй бөгөөд Хайлаар Манжуур зэрэг газарт орос монгол цэргүүд үзэгдсэн ба Манжуурын төмөр замын баруун нэгэн хэсэг газарт цөмрөн орохыг завдана хэмээжээ. Ийм зохиолын худал чимээг баримталж хятадын эрх баригчид дурдсан газрын цэргийг нэмж бусад элдэв хэргийг бэлтгэмүй хэмээжээ. Үүнийг үзвэл чөлөөт эрхтэй Монгол Улсыг хатган үймүүлэх зэргийн санаа гаргаж буй бөлгөө. Иймийн тул олон цэргийн захирал ба цэргүүд та бүгд дайсны муу хэрэг үүсгэхийг завдан бүхийг урьдаар сэргийлж буу зэвсгээ чанга баригтун.

Хятадын хоорондоо байлдаан гаргасан учир: Ши Баны хамгааллыг шүтэгч жанжин Жан Золин америк улсаас тусламжийг хүлээгч жанжин Оо Фи Фу нар харилцан байлдаж бүхий цагт хятадын далайн онгоц Оо Фи Фуд их л тус болжээ. Сонсвоос Жан Золины цэрэг ихэд дийлэгдэж үлдэгсэд нь зүүн зүгт сарнин явжээ хэмээмүй.

Зүүн гурван муж өөртөө эрхтэй болсон нь: Сонсвоос Жан Золин Оо Фи Фу нарын хоорондын дайны учраас зүүн гурван муж өөртөө эрхтэй болно хэмээн тунхаглажээ. Япон улсаас энэ хэрэгт хамаарах бодлого буй хэмээмүй.

Итали улсын Генуя хотын хуралдаан нь: Олон улсын хоорондын чухал сонин болбоос олон улсын төлөөлөгчид орос улсын өмнөх байдлыг хэлэлцжээ. Орос, герман хоёр чухал гэрээг тогтсон хойно, герман улс лугаа эрх ашгийг тэмцэгч англи, франц улс ба тэдэн лүгээ холбогдон буурай олон улс Генуя хотын хуралдааныг даруй хааж аргын улирлын найман сард Голланд

улсын Гааги хотод дахин хурал нээх санаатай ба энэ хуралдаанд орос улсын хэрэг нэгэн тийш болоогүй учир олон улсаас Орос улсад тусгай комисс томилж түүний улсын байдал ба мөнгө зээлэн өгч болох эсэхийг байцаамуй хэмээв.

Алс Дорнодын бүгд найрамдах улсын Япон лугаа байлдах хэрэг гарсан учир: Япон улсын тушаалаар үлдсэн Хафиливын цэргүүд алс дорнодын бүгд найрамдах улс лугаа дахин дайн үүсгэжээ. Владивосток хотын цагааны засгийн тэргүүлэгч Меркулов Японоос зөвшөөрөл олж Примор мужийн олон ардыг цэрэг элсэж алс дорнодын бүгд найрамдах улс лугаа байлдах тухай тунхаглажээ. Алс Дорнодын бүгд найрамдах улсын цэргүүд цагаан хулгай байлдахад тус нутгийн олон ардын партизан цэргүүдэд тусламж үзүүлж байна. Үлгэрлэвээс саяхан энэхүү партизан цэргүүдэд тусламж үзүүлж байна. Энэхүү партизан цэргүүд Никольский Уссурекийгээс гарсан Япон цэргийн төмөр зам галт тэргийг цохиж бутруулсан ба төмөр замын гүүрийг эвджээ.

Алс дорнодын бүгд найрамдах улсын цэрэг элссэн тухай: Япон улсын цэрэгт Алс дорнодын бүгд найрамдах улсаас Япон цэрэг ба цагаан цэргүүд лүгээ байлдах учир 45 нас хүртэлх эрчүүдийг бүрнээ элсэх учир зарлал гаргажээ хэмээмүй.

Орос газрын өлсгөлөнгийн тухай: Ставрополь мужид 50 түмэн хүмүүс өлсгөлөн тохиолджээ. Түүний 18 түмэн нь цөм хүүхэд буй.

Ижевский хотын орчимд өлссөн 35 түмэн хүн буй ба түүний доторх 15 түмэн хүүхэд үхэхэд хүрчээ. Бас Астрахань хотод тэнхэл хүчгүй болж унасан хүмүүсийг өдөр бүр босгосоор буй. Тэдний их төлөв нь хүүхэд буй.

Казани мужид өлссөн хүмүүс өвс, модны холтсыг аргалтай хольж иднэ. Мал адуу, гахай, тахиаг хэдийн төгсгөжээ. Үлгэрлэвээс аль нэгэн газар байсан 300 мориноос 17 үлдсэн, 200 үхрээс 10 үлдсэн буй. Мөн мужид долоо хоног дотор 3370 хүн үхжээ. Одоо бас хүнийг идэх удаа нэмэгдэнэ.

Тариалангийн ургацын өнгө:

Албаны чимээнд тэнгэр ба ус борооны байдлыг үзвээс ирэх жилийн тариалангийн ургацын өнгө сайн төлөвтэй үзэгдэнэ. Элбэгжих цагийг хүртэл тэнхрүүлэхийг оролдоно хэмээжээ.

Нийслэл Хүрэнээс Оросын өлсгөлөн тохиолдогсдод тусалсан зүйл:

Ноднин жил өвөл эхлэн энэ жил хавар цагийн эцэс хүртэл цугласан орос төгрөг нэгэн түмэн гурван мянга таван зуун арван долоо мөнгө гучин есөн дайг орос газраа хүргүүлжээ.

Өлсгөлөн хүмүүсийг хашраасан: Эстон баялаг улсын засгийн газраас тус улсын Рабал хотын үйлдвэр хурал өнгөрсөн таван сарын нэгний өдрөө. Орос өлсгөлөн хүмүүст тусламж үзүүлэх тухай мөнгө цуглуулахыг хоригложээ. Бас Харбин хот дахь Хятадын эрх баригчдаас оросын өлсгөлөн хүмүүсийг тэтгэх тухай сугалаа гаргахыг мөн хоригложээ.

Дотоодын сонин: Олон цэргийн тэжээл тухайн энгийн худалдааны хүмүүсийг эрхэлж манай сан яамнаас Хараа гол зэрэг газраар үлэмжхэн хэсэг газрыг тариалуулахаар тогтсон бөгөөд хэдий тарих цаг өнгөрсөн боловч уг төсөвлөн бодсон зуун хувь газраас гурван зуун хувь газрыг хагалбарлаж чадна хэмээв. Бас сангийн яамнаас өдөр бүр дөрвөн зуун фут татах тээрэм байгуулах санал буй хэмээнэ.

Нийслэл Хүрээг цэвэрлэвээс зохино: Манай нийслэл хотын буртаг бузар бүхийг хэн бүхнээр мэдэх билээ.

Олон зээл дээр нохой морь муурын хүүр ялзарч олон өвчний үндэс хөгжсөөр болохоос гадна зээлийн дундуур урссан Сэлбэ голоос хотын хүмүүс ус хэрэглэх нь бас ч элдэв өвчний үүсгэлд ноцтой холбогджээ. Үүнийг зүй нь олон гэрийн эздэд албадан тулгаж өөр өөрийн хашааны ойр бүхий адгуусны хүүр ба хогийг зайлуулбаас их л цэвэр ариун болох буй заа хэмээхээс гадна ялт хүмүүсээр цэвэрлүүлбээс болно. Бас Зөвлөлт орос улсын дүрмээр улаан цэргүүдээр хог цэвэрлүүлж мөн болох буй заа. Энэхүү хог арилгаж цэвэрлэх хэргийг хойшлуулж үл болно хэмээжээ. (Хураангуй сэтгүүл., Олноо өргөгдсөний 12-р он)

Энд нийтдээ 12 мэдээ байна. Үүн дээр өмнө дурдсан зөрүүтэй 7 мэдээг нэмнэ. Ингээд 19 мэдээлэл болж байгаа юм. Алгын чинээ хэмжээтэй жижигхэн сонин боловч монгол, орос хэлээр 19 мэдээг түмэн олондоо өргөн сонордуулжээ. “Хураангуй сэтгүүл”, “Бюллетень Монгольского Телеграфного Агентства /”МОНТА”/” сонинуудын 1922 оны /6-р сарын 22 ба 5-р сарын 25-ны өдрүүдийн/ анхны дугаараас бүтэн нэг зуун жилийн дараагаар өнөөгийн 21 дүгээр зууны уншигчид бид юу юуг олж мэдэж болохоор байна вэ гэдэгт одоо хариулт өгье. Анхны дугааруудад хэвлэгдсэн мэдээ мэдээллийн агуулгыг хураангуйлан тоймловол:

1. Эрх чөлөөт Монгол Улс нь эзэрхэг түрэмгийлэгч дайсны уур хилэнг бадрааж байна. Харбин хот дахь оросын сонин бичигт хятадын эрх баригчдын үг, үзэл бодлыг илэрхийлснээс харвал Монголын Засгийн газар Хөлөнбуйрыг эзлэн авах бодлого баримталж Хайлаар Манжуур зэрэг газарт орос, монгол цэргүүд үзэгдэх болж цөмрөн орохыг завдаж буй. Ийм

худал зохиомол үг, цуурхлыг үндэслэж Хятад улсын эрх баригчид тухайн районд цэрэг зэвсгийн хүчийг нэмэгдүүлж байгаа. Энэ нь чөлөөт эрхтэй Монгол Улсыг хатган үймүүлэх атгаг санааг агуулж байна.

Иймийн тул олон цэргийн захи-рагч ба цэргүүд сонор сэрэмжээ дээшлүүлж буу зэвсгээ чанга баригтун. Аюул занал ойрхон байна.

2. Ши Баны хамгааллыг шүтэгч жанжин Жан Золин, Америк улсын тусламжийг авсан жанжин Оо Фи Фу нар хоорондоо байлдаж байна. Энэхүү дайнд Хятадын далайн онгоц Оо Фи Фуд их тус хүргэжээ. Жан Золины цэрэг ихэд дийлэгдэж, үлдэхэд нь зүүн рүү сарнин зугтжээ.

3. Жан Золин ба Оо Фи Фу нарын хоорондын дайны үр дүнд зүүн гурван муж өөрсдийн эрх чөлөөтэй болсноо зарлан тунхаглажээ. Япон улс үүнд нөлөөлж буй гэнэ.

4. Олон улс орны төлөөлөгчид Генуя хотноо цугларан Орос оронд болж өнгөрсөн үйл явдлын талаар санал солилцож хэлэлцсэн байна. Орос, Герман хоёр улс чухал тохиролцоонд хүрч гэрээ байгуулжээ. Германы нэгэн адил өөрсдийн эрх ашгийг хамгаалан тэмцэгч Англи, Франц улс, тэнд цугларсан бусад буурай улс орнуудын төлөөлөгчид Генуя дахь хуралдаанаа өндөрлүүлж дараагийн уулзалтыг аргын улирлын 8-р сард Голландын Гаага хотноо зохион байгуулахаар санал гаргацгаасан аж. Уг хуралдаанаар Орос улсын хэрэг явдал нэгэн тийш болж чадаагүй тул олон улс орон өөрсдийн төлөөлөгчдийг Орос руу илгээж тус улсын байдлыг тандах, мөнгө зээл олгож болох эсэхийг судлах бодолтой байна.

5. Япон улсын тушаал заавраар Хафиловын цэргүүд Алс дорнодын бүгд

найрамдах улсад дахин дайн байлдаан хийж байна. Владивосток хотын цагааны талын засгийг тэргүүлэгч Меркулов Японы дэмжлэг зөвшөөрөлд дулдуйдаж Примор мужид цэрэг элсүүлж Алс дорнодын бүгд найрамдах улс лугаа байлдана гэж тунхаглажээ. Харин Алс дорнодын бүгд найрамдах улсын цэргүүдийг цагааны хулгайч нартай байлдахад нь орон нутгийн партизан цэргүүдэд нутгийн ард иргэд тусламж дэмжлэг үзүүлж байна. Партизан цэргүүд Никольский Уссурскийгээс гарсан Япон цэргийн төмөр замын галт тэргийг бут цохиж, бас төмөр замын гүүрийг эвджээ.

6. Алс дорнодын бүгд найрамдах улсад Япон цэрэг ба цагаан цэргүүд лүгээ байлдах цэрэг элсүүлж 45 хүртэлх насны эрчүүдийг цэрэгт татаж байна.

7. Оросын Ставрополь мужид 50 түмэн хүн өлсгөлөнд нэрвэгджээ. Тэднээс 18 түм нь хүүхдүүд юм.

Ижевский хотын орчимд өлсгөлөнд нэрвэгдсэн 35 түмэн иргэд байгаагаас 15 түмэн хүүхэд өлсөж үхэхийн даваанд тулж очжээ. Бас Астрахань хотод тамир тэнхэлгүй болсон хүмүүс унаж тусахад өдөр бүр арчлан босгож байна. Тэдний ихэнх нь хүүхдүүд байна. Казань мужид өлссөн хүмүүс өвс, модны холтсыг аргалтай хольж идэхэд хүрчээ. Мал адуу, гахай, тахиа бүгд барагджээ. Нэгэн газрын 300 мориноос 17, 500 үхрээс дөнгөж 10 нь үлдсэн гэнэ. Уг мужид 7 хоногт 3370 хүн өлсөж үхжээ. Хүний махаар хүнс хийж идэх үзэгдэл нэмэгдэж байна.

8. Албаны мэдээ, тэнгэр газрын байдлыг ажваас ирэх жилийн тариалангийн ургац сайн байх төлөвтэй. Сайн цагийг үзье гэвэл яаж ийж байгаад намар хүртэл тэсэх хэрэгтэй байна.

9. Өнгөрсөн өвлөөс өнөө жилийн хавар хүртэлх хугацаанд Орос орон

дахь өлсгөлөнд нэрвэгдэгсдэд зориулж нийслэл Хүрээнийхэн орос төгрөг нэгэн түм гурван мянга таван зуун арван долоон мөнгө гучин есөн дайг цуглуулж Орос оронд хүргүүлжээ /13.517 рубль 39 коп/. Албан хаагчид, ажилчид, ялангуяа улаан армийн цэргүүд энэ хөдөлгөөнд идэвхийлэн оролцсон байна.

10. Эстоны хөрөнгөтний засгийн газар 5-р сарын 1-нээр Оросын Нововольжийн өлсгөлөнд нэрвэгсдэд зориулж мөнгө цуглуулах хөдөлгөөн өрнүүлэхийг хоригложээ. Мөн дэлхийн нөгөө өнцөг дэх Харбин хот дахь Хятадын эрх баригчид Нововольжийн өлссөн хүмүүсийг тэтгэх зорилготой сугалаа гаргахыг бас хориглосон байна.

11. Хувийн өмчит худалдаачдаас үл хамааралтай байхын тулд манай Сангийн яамнаас Хараа голын хөндийд ихээхэн хэмжээний газарт цэрэг армийн хэрэгцээг хангах тариалалт явуулахаар шийдвэрлэжээ. Тариалах цаг хугацааг хожимдуулан өнгөрүүлж байгаа зэрэг дутагдал байвч төлөвлөсөн хэмжээт тариалалтын дөрөвний гуравт хагалбарлан үр суулган тариалж чадна хэмээн найдаж байна.

Үүнтэй холбогдуулж Сангийн яам нэгэн чухал алхмыг хийж 400 пуд үр тариа боловсруулах хүчин чадал бүхий салхин хөдөлгүүрт тээрэм барьж байгуулан тоноглохоор болсон байна /Улсын газар тариалангийн аж ахуйг эрхлэх болоод улсын чанартай тээрэм байгуулах зэрэг нь Европын болон Америкийн улс орнуудын хувьд жирийн нэг байдаг зүйл мөн боловч бэлчээрийн аж ахуйтай Монголын хувьд энэ нь олон талын ач холбогдолтой маш том үйл явдал юм. /Үүнийг “Хураангуй сэтгүүл”-д орчуулалгүй орхигдуулсан байна Т.Б./

12. Манай нийслэл хот-Хүрээ хог буртагт дарагдсаныг хэн хүнгүй мэднэ. Энд тэндгүй үхсэн нохой, адуу мал, муурын хүүр сэг хэвтэнэ. Энэ нь олон янзын өвчин үүсэх үндэс болдог.

Сэлбэ гол төв захын дундуур урсаж, түүнээс оршин суугчид ундны ус авч хэрэглэдэг. Зун болж халуун дулаан өдрүүд нэмэгдэхийн хэрээр элдэв өвчин үүсгэх, ялангуяа хүүхдүүд өвчлөх нөхцөл шалтгаан бүрдэж байна.

Орон гэрийн эзэд, худалдаа наймаа эрхлэгч нэг бүрд өөр өөрсдийн газар нутаг дахь хог новшийг цэвэрлэж, хүүр зэмийг арилгаж цэвэрлэж байхыг албадан даалгаж хэрэгжүүлэх хэрэгтэй юм. Хот хороог цэвэрлүүлэх эл ажилд шоронгийн ялтангуудыг дайчлан ажиллуулахад ч болохгүй юмгүй.

Зөвлөлт Орос улсад ийм практик байдлаас санаа авч ардын цэрэг эрс, улаан армийнхныг нэгэн зэрэг нэг өдрөөр ажиллуулж хог цэвэрлүүлж болох байна. Ахин хэлж сануулахад хожимдоогүй дээр яаравчлах шаардлагатай. /Залуучуудын эвлэлийн гишүүдийн дундах энэ чиглэлээрх ухуулга сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх хэрэгтэй юм. Т.Б. Үүнийг монгол хэл дээр орчуулалгүй орхижээ/ (Хураангуй сэтгүүл., Олноо өргөгдсөний 12-р он) (Бюллетень Монгольского Телеграфного Агентства, 1922) гэжээ.

Дүгнэлт:

1. “Хураангуй сэтгүүл” ба “Бюллетень МОНТА” сонинуудын 1922 оны анхны дугаарт нийтдээ 19 мэдээлэл нийтлэгдсэн байна.

Үүнээс 10 нь гадаадын улс орнуудад болж буй үйл явдлыг мэдээлсэн аж. Харин 9 нь Монгол Улс, монголчуудын дотоод аж амьдралтай холбоотой мэдээ мэдээлэл оржээ.

Дотоод болоод гадаад мэдээллийн тэнцвэрт харьцаа 49 ба 51 хувьтай байна.

Энэ бол маш боломжийн, туйлын ухаалаг сэдвийн тэнцвэрт харьцаа гэж хэлж болно. Энэ хэмжээгээр Монгол Улс, монголчуудыг гадаадад, гаднын уншигчдад сурталчилж, мөн тэр хэмжээгээр дэлхий дахинаа, ялангуяа хөрш зэргэлдээх улс орнуудын талаарх мэдээллийг Монголын уншигчдад хүргэжээ.

2. Энэ хоёр сонин та бидэнд эдүгээгээс нэг зуун жилийн өмнөх Монгол Улс, монголчуудын аж амьдралын талаарх хамгийн үнэ цэнтэй, бодит мэдээллийг товч болоод тодорхойгоор өгч чадаж байна. Заримаас нь ахин сануулж дурдвал:

- Тухайн цаг үед Өргөө хотод орон нутгаас буюу аймгуудаас заримдаа 50 тэмээ ачаа, заримдаа 300 тэмээ ачаа орж ирдэг байжээ. Харилцан адилгүй энэхүү жигд бус ханган нийлүүлэлтээс болоод бүтээгдэхүүний үнэ ханш хэлбэлзэж байж.

Хятадаас дарь сум оруулж ирэхийг хориглосны улмаас малчид, анчдын гар дээрх тарваганы арьсны тоо ширхэг цөөрч, нэг ширхэгийн үнэ нь Өргөө хотод 60 копейк хүрч байсан гэж мэдээлсэн байна. Тарваганы арьсыг сонирхогч гадаадын фирмүүд олон байна гэжээ.

- 1922 оны 5 дугаар сарын 20-21-ний өдөр Өргөө дэх Ардын ордонд халх, цахар, ордос, барга, Байгалийн цаадах болон Эрхүүгийн буриадууд, Астраханы болон Донын халимагууд, бас төвд, татаар, солонгос, хятад иргэдийн төлөөлөл оролцсон интернационалч концерт тоглогдсон байна.

Энэ ажлыг зохион байгуулалцахад манай нэрт зохиолч сэтгүүлч, 1921 оны Ардын хувьсгалын дууч, МХЗЭ-ийн Төв

Хорооны анхны дарга, монголын шинэ үеийн ший жүжгүүд, уран зохиол, сэтгүүл зүйн шүүмж судлалыг үндэслэгч Сономбалжирын Буяннэмэх идэвхийлэн оролцож байсан байна.

Заал үзэгчдээр пиг дүүрч, хоёр өдрийн тоглолтоос наймаас есөн зуун ам.долларын орлого олж, ОХУ дахь өлсгөлөнд нэрвэгсдэд хүргүүлж байжээ. Энэ бол сонирхолтой баримт юм.

- Тухайн цаг үед эрдэмтэн зохиолч И.Майскийн тооцоолж гаргаснаар монгол үндэстний тоо өвөрмонголчууд, Алтайн хязгаарын болон Хятадын хэд хэдэн газар нутаг дахь монголчуудыг оруулаад хоёр сая орчим байна гэжээ.

Үүнээс тусгаар тогтносон БНМАУ-д /1918 оны байдлаар/ 647 мянга нь байсан аж. Тэгэхдээ тэднээс 542 мянга нь монгол үндэстэн, 100 мянга нь хятад, 5 мянга нь оросууд байна гэж тодотгожээ. Туйлын өндөр үнэ цэнтэй мэдээлэл мөн.

- Монголын газар нутаг дээр Америкийн болон Оросын эрдэмтэд эрдэм шинжилгээний эрэл хайгуулын ажил хийж байгааг бас мэдээлсэн байна.

Оросын эрдэмтэн Г.В.Писарев морь унаж монголын нутгийг бүтэн тойрч Сибирийн газар тариаланд ихээхэн практик ач холбогдолтой, тэндхийн газар нутагт зохицон ургах чадвартай ургамал, үр тарианы үрийг эрж хайж буйг мэдээлсэн байна.

Америкийн газар зүй, геологи хайгуулын эрдэмтэд Монголд ирлээ гэж мэдээлсэн нь алдарт байгаль судлаач Эндрюсын шинжилгээний экспедицийг хэлж байгаа бөгөөд тус шинжилгээний анги 26 хүний бүрэлдэхүүнтэй, 75 тэмээ, 5 авто машинтайгаар Монголын нутгаар 3000 бээр газар явж говийн хойд хэсгээс балар эртний хөхтөн амьтны гавлын яс, араг ясны хэлтэрхий /Динозаврын/ зэрэг хөхтөн амьтны 2000

хүртэлх дээжис цуглуулж, маш олон зүйлийн шувуу, загас, могой олж тэдний зургийг ойроос авч, хулангийн сүргийн амьдралыг нарийвчлан судалсан болохыг “Бюллетень МОНТА” сонин сүүлд 1923 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийн № 50-51-д мэдээлсэн байдаг юм. Энэ бол тухайн цаг үедээ дэлхийг шуугиулсан шинэ нээлт байсан билээ.

- Өргөө хотын албан хаагчид, ажилчид, ялангуяа ардын армийн цэргүүд санал санаачилга гаргаж 11 дүгээр сараас 1922 оны 5-р сарын 1-ний хооронд 13517 рубль 39 копейк цуглуулж Орос орон дахь өлсгөлөнд нэрвэгдэгсдэд хүргүүлээ. Монголчууд ингэж идэвхийлэн зүтгэж байхад нийслэл дэх орос худалдаачид, үл хөдлөх хөрөнгө эзэмшигч эрс иргэд амласнаасаа гурав дахин бага хөрөнгө мөнгө цуглуулсан гэж “Бюллетень МОНТА” шүүмжилжээ.

- Хөрш зэргэлдээх Хятад гүрэн худал гүтгэлэг дэгдээж, түүгээрээ түрээ барин эрх чөлөөт Монголын баруун хойт хил Хайлаар Манжуурын чиглэлд цэрэг зэвсгийн их хүч хуралдуулж байгааг сэрэмжлүүлэн буу зэвсгээ чанга барин бэлэн байгтун гэж сонин уриалж байсан байна.

- Монголд газар тариаланг хөгжүүлж гурилын тээрэм байгуулахын чухлыг тэмдэглэж, Өргөө хот хог новшинд дарагдаж, үхсэн нохой, адгуус мал, муурын хүүр зэмээр дүүрэн байгааг анхааруулж, нийслэлээ цэвэр цэмцгэр байлгахыг уриалж байсан байна.

- “Хураангуй сэтгүүл”, “Бюллетень МОНТА” сонины газар, Монголын Цахилгаан мэдээллийн агентлагийн Тамгын газар Монголын ардын цэргийн Улстөрийн газрын байранд байрлаж буйг зарлан мэдээлж байсан нь ч бага зүйл биш юм.

Энэ бүгдийг товчлон базаж хэлэх юм бол “Хураангуй сэтгүүл”, “Бюллетень МОНТА” сонин тухайн цаг үеийнхээ толин тусгал болж чадаж байжээ. Монгол Улс, Монголын ард түмний 1920-иод оны үнэн түүхийг нэр төртэй тэмдэглэн бичиж үлдээсэн гэж бүрэн үндэстэй хэлж болохоор байгаа юм.

3. Онцгойлон тэмдэглэж хэлэх ёстой өөр нэг өнцөг бол Монгол Улс, монголын ард түмний тухайн цаг үеийн ажил үйлс, амьдрал тэмцлийг үнэн бодитойгоор гадаад ертөнцөд, юуны түрүүнд ОХУ, түүний уншигчдад цаг алдалгүй 7 хоногт 2 удаа түргэн шуурхай хүргэж байсан байна.

Хориод онд Монголд МОНЦАМЭ-гийн “Бюллетень МОНТА”-гаас өөр гадаад хэл дээр хэвлэгдэж гаднын уншигчдад тогтмол хүрдэг хэвлэл байсангүй. Зөвхөн орос хэлээр, ОХУ-аар дамжиж Монгол Улс, монголчууд гадаад ертөнцтэй холбогдож байв.

4. Үүнээс дутахгүй өөр нэг томоохон чухал ач холбогдол нь МОНЦАМЭ агентлаг, түүний “Хураангуй сэтгүүл” сонин дэлхийн нийтийн байдал, нөлөө бүхий томоохон гүрнүүд /Америк, Япон, Англи, Франц зэрэг/, ялангуяа хөрш зэргэлдээх Орос-Зөвлөлт ба Хятад улсын талаарх шинэхэн мэдээ мэдээллийг өөрийн орны уншигчдад тогтмол байнга хүргэж байсанд оршино.

“Хураангуй сэтгүүл”, “Бюллетень МОНТА” сонины анхны дугаарт эл сэдэв 51 хувийн үзүүлэлттэй байсныг дүгнэлтийн эхэнд дурдсан Манж Хятадын дарлал мөлжлөгт 220 жил нухчин дарлуулж хөмөрсөн тогоон дотор орсон мэт ертөнцөөс тасархай оршиж, гадаадын зарим эрдэмтэн, жуулчны нэг бус удаа тэмдэглэж үлдээснээр “Чингисийн монгол үндэстэн мөхөж сөнөж дуусч байна” гэгдэж, Монгол Улс хөгжил дэвшлээрээ дэлхийн улс орнуудаас

холын холд гээгдэж хаягдсан хорьдугаар зууны эцэс дэх тухайн цаг үеийн нөхцөл байдалд монголчууд хоцрогдлын гүн нойрноос сэргэж нүдээ нээн, бусдын сайн туршлага, дэвшилт зүйлсийг олж харж шинжлэх ухаан, соёл, боловсрол, эрүүлийг хамгаалах зэрэг олон салбарыг цоо шинээр хөгжүүлэн тэдэнд дөхөж очих явдал амин чухал зорилт байсан билээ.

Энэ эрхэм ариун үйлсэд үндэсний мэдээллийн МОНЦАМЭ агентлаг, түүний дээр нэрлэсэн сонин хэвлэл юугаар ч сольшгүй чухал үүрэг гүйцэтгэж байсан байна.

5. Хэн ч ажиглахгүй байж мэдэх нэг жижиг зүйлийг нэмж хэлэхэд “Бюллетень МОНТА” ба “Хураангуй сэтгүүл” нь үндэсний мэдээллийн МОНЦАМЭ агентлагийг дэлхийн бусад улс орон дахь мэдээллийн агентлагуудын нийтлэг жишиг, чиг хандлагад нийцүүлэн төлөвшүүлж хөгжүүлэх үйлсэд бас өөрсдийн хувь нэмрийг оруулсан гэж хэлэх байна.

Аль ч мэдээллийн агентлагийн үйл ажиллагааны гол үндсэн чиглэл бол өөрийн улс орноо гадаад ертөнцөд түгээмэл гадаад хэлээр тасралтгүй системтэй сурталчлах, дэлхий дахины байдал, бусад улс орнуудын хөгжил дэвшил, хүн ардынх нь амьдрал тэмцлийг өөрийн улсын уншигч, сонсогч, үзэгчдэд цаг алдалгүй мэдээлэх явдал байдаг билээ.

6. МОНЦАМЭ агентлаг, түүний “Бюллетень МОНТА” ба “Хураангуй сэтгүүл” Монголд дэвшилт шинэ тэргүүний зүйлийг шуурхай мэдээлж чөлөөт сэтгэлгээг хөгжүүлэх, 1913-1920 оны “Шинэ толь хэмээх бичиг”, “Нийслэл Хүрээний сонин бичиг” сонинуудын эхлүүлсэн чөлөөт хэвлэлийн харьцангуй өндөр түвшний үйл хэргийг нэр

төртэй үргэлжлүүлснийг хэлэхгүй өнгөрч яахан болох билээ.

Энэ сэдвээр би тусгайлан ном бичиж, “Хураангуй сэтгүүл” ба “Бюллетень МОНТА”-гаас монголын хэвлэлийн үүсэл, хөгжил, төлөвшилд оруулсан хувь нэмрийг үндсэн 9 үзүүлэлтээр нэгэнт 2000 оны эхээр тодорхойлон гаргасан тул энд зөвхөн сануулах төдийхнөөр өнгөрлөө.

Эшлэл

1. “Правда” сонин. 2021.3.30. №68 /Дөрөвдүгээр нүүрт хэвлэгджээ/
2. Миний нэр, миний гэр МОНЦАМЭ. УБ, 2001, 12 дахь тал
3. МАХН-ын төв архивт бий, намын анхдугаар их хурлын материал, гар бичмэл эх, 18 дугаар хуудас.
4. МАХН-ын Төв архивын 1 фондын 24 дүгээр товъёгийн 46 дугаар нэгжийн 34 дүгээр талд.
5. Г.Дэлэг. “Монгол тогтмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл” 306 дахь тал, Улаанбаатар 1965 он.
6. Бюллетень Монгольского Телеграфного Агентства. /”МОНТА”/. № 1, 25 мая 1922 года.
7. Хураангуй сэтгүүл. Дугаар 1. Олноо өргөгдсөний 12-р он. 4 сарын 27. Аргын улирлын 6-р сарын 22.
8. Хураангуй сэтгүүл. Дугаар 1. Олноо өргөгдсөний 12-р он. 4 сарын 27. Аргын улирлын 6-р сарын 22.
9. “Хураангуй сэтгүүл”, Дугаар 1. Олноо өргөгдсөний 12-р он. 4 сарын 27. Аргын улирлын 6-р сарын 22 ба Бюллетень Монгольского Телеграфного Агентства /”МОНТА”/. № 1, 25 мая 1922 года.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. “Бюллетень Монгольского Телеграфного Агентства”. 6 дугаар сарын 22. /”МОНТА”/, №1, 25 мая 1922 года.
2. “Хураангуй сэтгүүл”. Дугаар 1. Олноо өргөгдсөний 12-р он. Аргын улирлын 6-р сарын 22.

3. “Правда” сонины 1921 оны 3 дугаар сарын 30, № 68. Монголчуудын бослого.
4. Тугалхүүгийн Баасансүрэн. XX зууны эхэн үеийн Монголын чөлөөт хэвлэл. /Тэргүүн дэвтэр, I хэсэг/.
5. Миний нэр, миний гэр МОНЦАМЭ. УБ, 2001.
6. МАХН-ын төв архив. Намын анхдугаар их хурлын материал /Гар бичмэл эх/.
7. Г.Дэлэг. Монголын тогтмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл. УБ, 1965.
8. Тугалхүүгийн Баасансүрэн. XX зууны эхэн үеийн Монголын чөлөөт хэвлэл. УБ. 2009.

Summary

The Mongolian National News Agency MONTSAME was founded on July 19, 1921. Soon after that, on May 25, 1922, the first issue of the newspaper Bulletin of the Mongolian Telegraph Agency was published in Russian. On June 22, 1922, the Mongolian version of the newspaper Khuraangui Setguul was published. A total of 19 news items were published in two newspapers. The texts in Russian and Mongolian have basically the same content, although some news in Russian has not been translated into Mongolian. The articles were carefully analyzed and studied by the author. 9 of the news of the two newspapers are related to Mongolia and the internal life of the Mongols, and 10 are foreign news. The ratio of domestic and foreign news of the first Mongolian and Russian-language newspapers MONTSAME was 49 to 51%.

The researcher emphasizes that MONTSAME from the very beginning adhered

to this reasonable balance of information in its newspapers, and notes the exceptional importance of century-old news to provide readers of that time with valuable and objective facts about the country and beyond, confirming his research, for example, with data from the Mongolian census (as of 1918), discoveries and results of research work of Russian and American geographical expeditions of that time in Mongolia.

The efforts of the Mongolian news agency MONTSAME in disseminating information about Mongolia and the Mongols around the world through the publication of a newspaper in Russian, which was published twice a week in 1922, are especially noted. This indicates that the Mongolian news agency MONTSAME, since its inception, has developed in accordance with the development trend of world news agencies.

In 2009, Dr. T.Baasansuren published the book “Mongolian Free Press of the Early 20th Century” (parts I and II) with a detailed analysis of publications in the publications “Khuraangui setguul” /Consolidated journal/ and “MONTA Bulletin”. This time the author shares his observations on all the articles in the first issues of these two newspapers. Based on his analysis of the publications of the first issues of “Khuraangui setguul” /Consolidated magazine/ and “MONTA Bulletin”, the researcher notes that these two newspapers adequately continued the relatively high level of free press laid down by the newspapers “Shine toli hemeeh bichig” /New Mirror/ and “Niislel Khurenii sonin bichig” /Capital news/ in 1913-1920.